

**МОНГОЛ УЛСАД ГЕОЛОГИЙН САЛБАР ҮҮСЧ ХӨГЖСӨНИЙ 72 ЖИЛ, МОНГОЛЫН
ГЕОЛОГИЙН ХОЛБОО ҮҮСГЭН БАЙГУУЛАГДСАНЫ 15 ЖИЛ, МОНГОЛЫН
ГЕОЛОГИЧДИЙН ӨДРИЙГ ТОХИОЛДУУЛАН ЗОХИОН БАЙГУУЛАХ 2011 ОНЫ
“ШИЛЖИН ЯВАХ ЦОМ” ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ**

Тэмцээний зорилго

Нийтийн биеийн тамир, спортыг дэмжих үндэсний хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсад Геологийн салбар үүсч хөгжсөний 72 жил, Монголын Геологийн Холбоо үүсгэн байгуулагдсаны 15 жил, Монголын “Геологичдийн өдөр”-ийг тохиолдуулан зохион байгуулах 2011 оны “Шилжин явах цом” спортын олон төрөлт уламжлалт тэмцээнийг геологийн салбарт үйл ажиллагаа явуулж буй байгууллага, аж ахуйн нэгжүүдийн ажилтнуудын дунд спортын 4 төрлөөр зохион байгуулахад тэмцээний зорилго оршино

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Спортын төрлүүд

Сагсан бөмбөг (эрэгтэй, эмэгтэй),
Гар бөмбөг (эрэгтэй, эмэгтэй),
Шатар (холимог баг),
Ширээний теннис (холимог баг),

1.2. Тэмцээний тов

Тэмцээн 2011 оны 10 дугаар сарын 8-9-ний өдрүүдэд Улаанбаатар хотын Буянт Ухаа дахь спортын цогцолборт явагдана.

1.3. Тэмцээнийг зохион байгуулах байгууллага

Тэмцээнийг Монголын Геологийн Холбоо, Ашигт Малтмалын Газар хамтран зохион байгуулна.

1.3 Шагнал

Тэмцээний төрөл тус бүрд нэг, хоёр, гуравдугаар байр эзэлсэн багуудад медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал олгоно. Тэмцээний төрлүүдийн нийлбэр дүнгээр нэгдүгээр байр эзэлсэн байгууллага, аж ахуйн нэгжийн багт “Шилжин явах цом”, өргөмжлөл, мөнгөн шагнал, багаараа хоёр, гуравдугаар байр эзэлсэн багт өргөмжлөл, мөнгөн шагнал олгоно.

Хоёр. Тэмцээний заавар

2.1. Тэмцээнд оролцох хураамж болох 100 000 /нэг зуун мянга/ төгрөгийг баг тус бүр бэлнээр төлнө. Төлбөрийг техникийн зөвлөгөөн дээр зохион байгуулагчид хүлээлгэн өгөх бөгөөд хураамжийг ямарч тохиолдолд буцаан олгохгүй.

2.2. Тоглолтын дэг, хуваарь, эхлэх болон дуусах хугацаа, дарааллыг техникийн зөвлөгөөнөөр сугалаагаар тогтооно. Сугалаа сугалсанаас хойш тэмцээнд өөр багийг нэмж оролцуулахгүй.

2.3. Байгууллага, аж ахуйн нэгжүүд сагсан бөмбөг болон гар бөмбөгийн төрөлд өөрийн үндсэн ажилтануудаас бүрдсэн сагсан бөмбөгийн 8 хүний, гар бөмбөгийн 9 хүний бүрэлдэхүүнтэй эрэгтэй, эмэгтэй баг тус бүр нэг багийг, ширээний теннисний төрөлд 3 (2 эрэгтэй, 1 эмэгтэй), шатрын төрөлд 3 (2 эрэгтэй, 1 эмэгтэй) хүний бүрэлдэхүүнтэй холимог багуудыг тус тус оролцуулахаас гадна тэмцээнд оролцож буй тамирчид нь тухайн байгууллага, аж ахуйн нэгжид 3 сараас доошгүй хугацаанд ажилласан байна.

Сагсан бөмбөг болон гар бөмбөг, ширээний теннисний төрөлд баг тус бүр тоглолтын цайвар өнгийн нэг, тод ялгарах бараан өнгийн нэг, ар өвөрт хувийн дугаар бүхий тоглолтын ижил өмсгөл /богино өмд,

майк, футболка/-гэйгээр оролцоно. Хувцасны өнгө ижил байх эсвэл төстэй байх тохиолдолд талбайн эзэн буюу тоглолтын хуваарьт зүүн гарт бичигдсэн баг тоглолтын өөр өнгийн нөөц хувцасаа сольж өмсөнө.

2.4. Тэмцээнд тухайн байгууллагын **үндсэн ажилтануудаас** өөр хүн оролцуулахгүй. Тухайн тоглогч/ажилтан/-ийн иргэний үнэмлэх, нийгмийн даатгалын дэвтэр, ажлын үнэмлэх, ажилд орсон тушаалыг шалгаж тэмцээнд оролцох мандатыг олгоно.

Мандатыг зөвхөн 10-р сарын 6-ны өдөр олгох бөгөөд мандатгүй тамирчинг тэмцээнд оролцуулахгүй. Багийн ахлагч нар техникийн зөвлөгөөнийн хуралд ирэхдээ оролцох тамирчдынхаа сүүлийн нэг жилийн дотор авахуулсан 1% цээж зургийг авч ирнэ.

2.5. Сагсан бөмбөг, гар бөмбөг, ширээний теннисний тэмцээнд аливаа лигийн тамирчин, улсын аварга шалгаруулах тэмцээнд сүүлийн 3 жилд оролцсон тамирчинг уг тэмцээнд оролцуулахгүй. Дээрх тэмцээнүүдэд тамирчин оролцсон эсэхийг тухайн төрлийн тэмцээний шүүгч тогтоох бөгөөд тэмцээнд оролцогч багийн ахлагч, дасгалжуулагч нараас бичгээр гаргасан хүсэлтээр дахин шалгаж болно.

2.6. Энэхүү зааврын 2.4. болон 2.5. заалтыг зөрчсөн нь тэмцээний ямарч үед тогтоогдвол тухайн тоглогч оролцсон багийн өмнөх тоглолтуудыг хожигдсонд тооцон /сагсан бөмбөг 20:0, ширээний теннис 3:0, шатар 5:0/ тухайн багийг бүх төрлийн тэмцээнээс бүрмөсөн хасна.

2.7. Тэмцээнд оролцогч баг энэ зааварт заасан журмыг зөрчсөний улмаас тэмцээнээс хасагдсан тохиолдолд тэмцээнд оролцох эрхийн хураамжийг буцаан олгохгүй.

2.8. Тэмцээнтэй холбогдон гарч болох маргаантай асуудлыг багийн ахлагчаар дамжуулан зохион байгуулагчид дамжуулан шийдвэрлэнэ.

2.9. Тэмцээнд оролцох тамирчдийн мэдүүлгийг доорх хаягаар хүлээн авах ба эцсийн хугацаа 2011 оны 10 сарын 6-ны өдрийн 14:30 цаг байна. Үүнээс хойш мэдүүлэг өгсөн багийг тэмцээнд оролцуулахгүй бөгөөд мэдүүлэгт өөрчлөлт оруулахгүй. /Мэдүүлгийн маягтын зааврыг хавсаргав/.

Техникийн зөвлөлгөөн 2011 оны 10 сарын 6-ны өдрийн 15:00 цагт Ашигт малтмалын газрын 3 давхарын уулзалтын танхимд болно.

Гурав. Тэмцээний журам

3.1 Сагсан бөмбөг

Оролцогч багуудыг А, Б, В, хэсгүүдэд хувааж тойргоор тоглолт явуулан байруудыг тодорхойлох ба эхний хэсэг тус бүрээс эхний хоёр байранд орсон багийг дараагийн шатны тоглолтод шалгаруулна. Хэрэв эрх авсан багууд 8-аас дээш байвал дахин хэсгүүдэд хувааж тойргийн журмаар тоглоно. Хэсэг тус бүрээс нэг, хоёрдугаар байр эзэлсэн багуудыг олимпийн системээр тоглуулж аваргыг шалгаруулж байр эзлүүлнэ.

Хэсгийн эрэгтэй багуудын тоглолт бохир цагаар талдаа 8, эмэгтэй багуудын тоглолт бохир цагаар талдаа 6 минут, эрэгтэй багуудын хагас шигшээ болон шигшээ тоглолт цэвэр цагаар талдаа 8 минут, эмэгтэй багуудын хагас шигшээ болон шигшээ тоглолт цэвэр цагаар талдаа 6 минутаар 2 үе байна. Торгуулийн шидэлт, минутын амралт тоглолтын хугацаанд хамаарахгүй.

3.2 Гар бөмбөг

Оролцогч багуудыг А, Б, В, хэсгүүдэд хувааж тойргоор тоглолт явуулан байруудыг тодорхойлох ба эхний хэсэг тус бүрээс эхний хоёр байранд орсон багийг дараагийн шатны тоглолтод шалгаруулна. Тойргийн тоглолтын дараа багуудын хожлын оноо тэнцсэн тохиолдолд хэсэг дотроо тоглосон нийт багуудын тоглолтын ээлжийн харьцааг дүгнэж дүнг гаргана. Хэрэв эрх авсан багууд 8-аас дээш байвал дахин хэсгүүдэд хувааж тойргийн журмаар тоглоно. Хэсэг тус бүрээс нэг, хоёрдугаар байр эзэлсэн багуудыг олимпийн системээр тоглуулж аваргыг шалгаруулж байр эзлүүлнэ.

Эрэгтэй тоглолт 21 оноо, эмэгтэй тоглолт 21 оноо нэг үед байх бөгөөд эхэлж 2 үед хожсон багт хожил өгнө. Контр гарсан тохиолдолд 3 дахь үед 15 оноогоор хожлыг тодорхойлно.

3.3 Шатар

Шатрын төрөлд багийн тамирчид 1, 2, 3 дугаар ширээнд тоглохдоо тамирчдын мэдүүлгийн дагуу хуваарилагдана. 1-р ширээний тоглогч 1-р ширээний тоглогчтойгоо, 2-р ширээний тоглогч 2-р

ширээний тоглогчтойгоо гэсэн зарчмаар тойргоор тоглоно. Орлон тоглогч аль ч ширээнд сууж болох боловч эрэгтэй тоглогч эмэгтэйг орлохгүй.

Тоглолтын хяналтын хугацаа тоглогч бүрт 10.00 минут байна. Багуудын хоорондын тоглолтын харьцаагаар хожсон багт 2 оноо, тэнцвэл нэг оноо, хожигдвол 0 оноо өгч дүнг гаргана. Оноо их цуглуулсан байрлалын дарааллаар байр эзлүүлж дүгнэнэ.

Багууд хоорондоо оноогоор тэнцсэн тохиолдолд нийт тоглолтоос оноо цуглуулсан дараалалаар, дахин тэнцвэл хоорондын тоглолтын 1,2,3-р ширээний тоглогчдын дүнгийн дарааллын чанараар, дахин тэнцвэл 1-р ширээнд хараар тэнцэл авсан багийг эхний байранд оруулах зарчмаар байр эзлүүлж дүгнэнэ.

3.4 Ширээний теннис

Оролцогч багуудыг А, Б, В, хэсгүүдэд хувааж тойргоор тоглолт явуулан байруудыг тодорхойлох ба эхний хэсэг тус бүрээс эхний хоёр байранд орсон багийг дараагийн шатны тоглолтонд шалгаруулна. Багийн тамирчид 1, 2, 3 дугаар ширээнд тоглохдоо тамирчдын мэдүүлгийн дагуу хуваарилагдана. 1-р ширээний тоглогч 1-р ширээний тоглогчтойгоо, 2-р ширээний тоглогч 2-р ширээний тоглогчтойгоо гэсэн зарчмаар тойргоор тоглоно. Хэрэв эрх авсан багууд 8-аас дээш байвал дахин хэсгүүдэд хувааж тойргийн журмаар тоглоно. Багуудын хоорондын тоглолтын харьцаагаар хожсон багт 2 оноо, хожигдвол 0 оноо өгч дүнг гаргана. Хэсэг тус бүрээс нэг, хоёрдугаар байр эзэлсэн багуудыг шалгаруулан олимпын системээр тоглуулж аваргыг шалгаруулж байр эзлүүлнэ.

Эрэгтэй, эмэгтэй тоглолт нэг үед 11 оноо байх бөгөөд эхэлж 2 үед хожсон тамирчинд хожил өгнө.

3.5. Тэмцээнийг дүгнэх журам

Тэмцээнийг “Бага оноо цуглуулах систем”-ээр дүгнэж, төрөл тус бүрд дараах журмаар байр эзлүүлнэ: Төрөл тус бүрт баг болгонд 1-р байрт 1 оноо, 2-р байрт 2 оноо өгөх гэх мэтээр 6-р байрт 6 оноо өгнө. 5 болон түүнээс хойш байрыг тодорхойлох боломжгүй тохиолдолд буюу 5-8-р байр эзэлсэн багуудад 5 оноо, 9-16-р байр эзэлсэн багуудад 9 оноо өгнө.

Тухайн төрөлд оролцоогүй багт боломжит хамгийн өндөр оноог өгч нийлбэр дүнд нэгтгэнэ. Тухайлбал 9-16-р байр эзэлсэн байх магадлалтай тохиолдолд 16 оноо өгнө.

Тойргийн тоглолтын дараа багуудын хожлын оноо тэнцсэн тохиолдолд хэсэг дотроо тоглосон нийт багуудын тоглолтын харьцааг дүгнэж гаргана. Багийн дүнгээр хоёр болон түүнээс дээш багууд оноо нь тэнцсэн тохиолдолд медалийн чанараар эхний багийг тодруулна. Дахин тэнцсэн тохиолдолд олон тоглогчдыг хамарсан төрлөөр буюу гар бөмбөг /эхлээд эмэгтэй, дараа нь эрэгтэй/, сагсан бөмбөг /эмэгтэй, дараа нь эрэгтэй/, шатар, ширээний теннис гэсэн дараалалын дагуу тэмцээний амжилтаар байр эзлүүлнэ.

3.6. Тэмцээнд оролцох багуудын мэдүүлгийг хүлээн авах хаяг

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Барилгачдын талбай-3, Төрийн өмчийн 5-р байр.
Баруун жигүүр. АМГ-ын Геологи, судалгааны хэлтэс, 405 тоот өрөө

Харилцах утас: 51-26-37-52, 8811-9877

E-mail: bslmaa@gmail.com

Зохион байгуулагчид

МОНГОЛЫН ГЕОЛОГИЙН ХОЛБОО

АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗАР

**МОНГОЛ УЛСАД ГЕОЛОГИЙН САЛБАР ҮҮСЧ ХӨГЖСӨНИЙ 72 ЖИЛ, МОНГОЛЫН
ГЕОЛОГИЙН ХОЛБОО ҮҮСГЭН БАЙГУУЛАГДСАНЫ 15 ЖИЛ, МОНГОЛЫН
ГЕОЛОГИЧДИЙН ӨДӨРТ ЗОРИУЛСАН ТЭМЦЭЭНД ОРОЛЦОХ-ААС
ОРОЛЦОХ БАГ ТАМИРЧДЫН МЭДҮҮЛГИЙН ЗАГВАР**

Сагсан бөмбөг /эрэгтэй, эмэгтэй баг/

Д/д	Овог нэр, регистрийн дугаар	Нас, биеийн өндөр	Спортын зэрэг, цол	Ямар байрлалд тоглох	Хувийн дугаар	Эрүүл мэнд
1						
2						
3						
4						
5						
6						
7						
8						
9						

Багийн ахлагч

Багийн дасгалжуулагч

Огноо